



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/154

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Сумдын төвийн нэгдсэн халаалтын шугамд холбох ажлын талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан хүсэлт ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн ажлын тоо хэмжээ, чанар, стандартыг дахин нягтлан шалгаж төсөв тооцоо өртөг нь зах зээлийн ханштай адил хэмжээтэй хийсэн талаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ш.Мөнхзаяа

- Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Гишүүд:

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Зөвлөх багийн ахлагч

Р.Янжмаа

- Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Г.Тунгалаг

- Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

- Холбогдох сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн

дарга: С.Өнөржаргал

- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. Холбогдох сумдад хийгдсэн ажлуудыг стандартын дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэсэн эсэхэд нягтлан шалгаж дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ш.Мөнхзаяа/- д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02.0970
D/Zah-A/154-Bo

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /З.Өмиртай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН